



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Г “Эрээнцав” ХК-ийн нэгдмэл сонирхолтой  
хувьцаа эзэмшигчдээс Компанийн тухай хуулийн 57.1 дэх  
заалтыг хэрэгжүүлэх, хувьцааг худалдан авахаар  
гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрээнцав” ХК-ийн нийт гаргасан 99,720 ширхэг хувьцааны 53,26 хувь буюу 53,126 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Г.Одгэрэл, Г.Оюун, Г.Отгонгэрэл нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 46,74 хувь буюу 46,594 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 3707 /гурван мянга долоон зуун долоо/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2014 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Эрээнцав” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Г.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

1/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах;

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000068